



**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.9 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 102 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 150 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлд болон зарим аймгуудад бүх шатны боловсролын байгууллага, сургалтын үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн түр зогсоож байгаатай холбогдуулан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед авч хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний удирдамж, чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Улсын онцгой комисс, Засгийн газраас баталсан шийдвэр болон энэхүү тушаалаар батлагдсан удирдамж, чиглэлийг үйл ажиллагаандаа баримтлан, хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны нэгжийн дарга нар болон нийт албан хаагчид үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /О.Хуягцогт/-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Д.БАТБААТАР

14202 0266

Боловсрол, шинжлэх ухааны
яамны Төрийн нарийн бичгийн даргын
2020 оны 11 дүгээр сарын 11-ний
өдрийн тушаалын хавсралт



**ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖСЭН ҮЕД АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ
УДИРДАМЖ, ЧИГЛЭЛ**

Нэг. Зорилго

1.1. Нийслэлийн бүх шатны боловсролын байгууллага, сургалтын үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн түр зогсоож байгаатай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны хэмжээнд Гамшгаас хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, стандартыг хэрэгжүүлж, гамшиг, осол болон урьдчилан сэргийлэх, Ковид-19 вирусын халдвараас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, салбарын энэ чиглэлийн үйл ажиллагааг тасралтгүй, шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах

Хоёр. Нийтлэг зохицуулалт

2.1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаа нь 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн түр хугацаанд үргэлжилнэ. Улсын онцгой комисс, Засгийн газраас хугацаа сунгасан тохиолдолд тухайн хугацаанд ажиллана.

2.2. Боловсрол, шинжлэх ухааны яамны шуурхай удирдлагын ажлын хэсэг нь иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагаас цаг үеийн холбогдолтой санал, хүсэлт, мэдээ, мэдээллийг дараах утас болон цахим хаягаар хүлээн авна. Үүнд:

Фэйсбүүк хаяг:	Утас:	И-майл хаяг:
Боловсрол, шинжлэх ухааны яам	Санал хүсэлт хүлээн авах утас:18001209	1209@mecs.gov.mn

2.3. Шуурхай удирдлагын ажлын хэсэг нь Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай штабтай 262022 /гар утаснаас-51-262022/ дугаарын утсаар холбогдож өдөр бүр 09:00 цагт мэдээгээ өгч, Obeg.shuurkhaishtab@gmail.com и-майл хаяг руу тайлагнана.

2.4. Шуурхай удирдлагын ажлын хэсэг нь яамны удирдлагад мөн өгч байх ёстой.

2.5. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан тус яамны мэргэжилтэн, нэгжийн дарга нартай албан ажил, хэргээр иргэд, харилцагч төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл биечлэн уулзах шаардлагатай бол нэгдүгээр давхарт Төрийн захиргааны удирдлагын газраас тусгай бэлтгэсэн өрөөнд уулзалтыг зохион байгуулна.

2.6. Энэхүү удирдамжийн 2.5-т зааснаас бусад тохиолдолд яамны ажилтан, албан хаагчдын өрөөнд иргэдийг зөвшөөрөлгүй нэвтрүүлэхгүй байна.

2.7. Яаманд нэвтэрч буй ажилтан, албан хаагчийн биеийн температурыг өглөө ажилд ирэхэд нь хэмжих, мөн бусад төрийн болон төрийн бус байгууллага, иргэд албан ажлын шаардлагаар дотогш нэвтрэх тухай бүр биеийн температурыг хэмжих ба амны хаалт /маск/, гар ариутгалгүй, халуунтай байгаа нөхцөлд тухайн иргэн, эсвэл ажилтан, албан хаагчийг ажлын байранд дотогш нэвтрүүлэхгүй байх, эрүүл мэндийн байгууллагад хандан эмчлүүлэхийг зөвлөж энэ талаар яамны шуурхай ажлын хэсэгт Төрийн тусгай хамгаалалтын газрын Харуул хамгаалалтын албаны Шалган нэвтрүүлэгч ажилтан нь мэдэгдэнэ.

Гурав. Шуурхай удирдлагын ажлын хэсгийн чиг үүрэг

3.1. Шуурхай удирдлагын ажлын хэсэг нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яам болон харьяа байгууллагаас авч хэрэгжүүлэхээр батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, холбогдох байгууллага, удирдлагыг цаг үеийн нөхцөл байдлын талаарх зарлал, холбоо мэдээллийг шуурхай зохион байгуулах, шуурхай жижүүрийг томилон ажиллуулах бөгөөд дараах чиг үүргийг тогтмол хэрэгжүүлж ажиллана.

3.1.1. Мэргэжлийн байгууллагаас гаргаж байгаа сэрэмжлүүлэг, зөвлөмжийг цаг алдалгүй байгууллагын хамт олон, харьяа байгууллагуудад яамны дотоод сүлжээ, олон нийтийн бусад сүлжээ, цахим хаягаар хүртээмжтэй хэлбэрээр шуурхай дамжуулан мэдээлэх;

3.1.2. Шинэ короновирусын болзошгүй халдварын тохиолдлын үед эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага, комисст мэдээллийг шуурхай хүргэх;

3.1.3. Нөхцөл байдлын талаар болон дээд байгууллага, яамны удирдлагаас гаргасан шийдвэр, холбогдох мэдээллийг байгууллага, салбар нэгжийн удирдлага, ажилтан, албан хаагч нарт тухай бүр мэдээлэх

3.1.4. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар нийслэлийн болон улсын онцгой комисс болон холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд байнга танилцуулах;

3.2. Шуурхай удирдлагын ажлын хэсгийн ахлагч нь яам болон харьяа байгууллагын шуурхай ажлын хэсгийн жижүүрийн мэдээллийг тогтмол авч, яамны удирдлагыг мэдээллээр хангаж ажиллана.

3.3. Шуурхай удирдлагын ажлын хэсгээс гаргасан хуваарийн дагуу томилогдсон жижүүр нь Боловсрол, шинжлэх ухааны яаманд өглөө 8:30 цагаас орой 18:00 цаг хүртэл ажиллаж, дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.1. Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан яам, харьяа байгууллага, нийслэл болон орон нутаг дахь салбарын харьяа байгууллага, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн цаг үеийн шуурхай аливаа мэдээллийг цаг, минуттай нь бүртгэн, тэмдэглэл хөтөлж, нэн даруй Шуурхай удирдлагын ажлын хэсгийн ахлагч болон Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай штабын жижүүрт тухай бүр мэдээлэх;

3.3.2. УИХ, Засгийн газар болон Улсын онцгой комисс, Онцгой байдлын албанаас ирүүлсэн мэдээ, үүрэг чиглэлийг тухай бүр нь Шуурхай удирдлагын ажлын хэсэгт болон яамны нийт ажилтан, албан хаагчдад мэдээлэл хүргэх ажлыг хариуцан зохион байгуулах;

3.3.3. Жижүүрийн үүрэгт ажлын тайланг тусгайлан гаргасан дэвтэрт тэмдэглэл үйлдэн тайлагнаж, дараагийн жижүүрт биечлэн хүлээлгэн өгч гарын үсэг зурж баталгаажуулах.

Дөрөв. Боловсрол, шинжлэх ухааны яамны ажилтан, албан хаагчийн чиг үүрэг

4.1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны нийт албан хаагчид, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Яамны албан хаагч бүр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Гамшгаас хамгаалах тухай хууль болон гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллага, улсын болон орон нутгийн онцгой комиссын үүрэг, чиглэл, удирдамжийг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас зарлан мэдээлсний дагуу ажлын тусгай горим, хорио цээрийн дэглэмийг мөрдөж ажиллах;

4.1.2. Ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийг /ганц бие эцэг/ байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ цахимаар ажиллах зохицуулалтыг Төрийн нарийн бичгийн даргын баталсан заавар чиглэлийн дагуу зохион байгуулна.

4.1.3. Гэрээсээ цахимаар ажиллаж байгаа албан хаагчийг хариуцсан чиг үүргийн хүрээнд ажлын хийдэл, орхигдол гаргах, дээд байгууллага, удирдлагаас өгсөн хугацаатай үүрэг, даалгавар удаашрах, хариуцлага алдах аливаа эрсдэл, зөрчил гаргахгүй байх талаар нэгжийн дарга бүр анхаарч, болзошгүй эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлж, шаардлагатай удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

4.1.4. Олон хүнийг хамарсан /8 буюу түүнээс дээш/ уулзалт, хурал, хэлэлцүүлэг болон зөвлөгөөнийг аль болох зохион байгуулахгүй байх, зайлшгүй

шаардлагатай нөхцөлд оролцогчдын тоог цөөн байлгах, эсвэл цахим мэдээллийн хэрэгслийг ашиглан оновчтой хувилбараар зохион байгуулах;

4.1.5. Биечлэн уулзах зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагаас тавьсан санал, хүсэлт, өргөдөл, гомдлын хариуг хүнд суртал, чирэгдэлгүйгээр шуурхай судлан, шийдвэрлэж телефон утас, цахим мэдээллийн хэрэгсэл болон бичгээр тухай бүр хариуг өгч ажиллах.

4.2. Нэгжийн дарга болон мэргэжилтнүүд өөрийн эрхлэх ажил, үүрэгт хамаарах асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэн зөв, баталгаатай мэдээллийг олон нийтэд хүргэх, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шуурхай дамжуулах үүрэгтэй. Яамны ажилтан, албан хаагчид нь удирдлагаас зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан ажлын талаарх мэдээлэл, цаг үеийн тулгамдсан, олон нийтийн анхаарал татсан аливаа асуудлаар байгууллагын байр суурийг илэрхийлэхгүй байх, олон нийтийг төөрөгдүүлэхээс зайлсхийх.

Тав. Тайлагнах

5.1. Шуурхай ажлын хэсгээс томилогдсон жижүүр нь үүрэг гүйцэтгэх хугацаанд болон дараагийн жижүүрт хүлээлгэн өгөхөд жижүүр хийсэн тэмдэглэлийг хөтөлж, баталгаажуулах ба Шуурхай удирдлагын ажлын хэсгийн дарга болон Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай штабт мэдэгдэнэ.

5.2. Яам болон харьяа байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар болон Улсын онцгой комисс, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн мэдээлэл, тайланг нэгтгэн гаргаж, хүргүүлэх ажлыг Шуурхай удирдлагын ажлын хэсгээс зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.

---oO---